

МОНГОЛЫН ТҮҮХЭН ДЭХ 1206 ОН

Г.Сэр-Од. Үдэсний төв архив

Өгүүллийн товч утга: Түүх бол цаг хугацааны шүүх билээ. Бид энэ удаа найман зуугаад жилийн тэртээ морин дэл дээр салхи мэт дүүлэн давхиж, нум сум болон бусад зэр зэвсгийг хүүхдийн тоглоом мэт эзэмшин хүн төрөлхтөний он тооллын нэгэн үеийн эзэгнэн явсан Чингис хаан тэргүүтэй өвөг дээдсийнхээ үйл хэргээс эргэн санахыг хүснэм. Чухамдаа **1206 он** бол Монгол туургатны аж амьдрал, ахуй суртал, цэрэг- улс төрийн бэхжилт дэвшилд гарч нэгэн хүчирхэг нэгдсэн улс байгуулах төр ёс болон түүхийн чухал үе байсан бүлгээ.

Түлхүүр үгс : Хамаг Монгол улс, Их Хуралдай, 1189 он, 1206 он, тархай бутархай байдал эцэслэв, Их Монгол Улс, Чингис хаан, Их Засаг

Алваа түүхэн үйл явцын урьдчилсан нөхцөл нь орон зай, цаг хугацаа, хүмүүсийн дэвшилт үйл ажиллагаа хэмээн үзвэл орон зайн тухай ухаан бол түүхэн газарзүй, түүхэн цаг хугацааны ухаан болох хронологи нь түүхийн судалгаанд онцгой ач холбогдолтой болой.

Сүлийн жилүүдэд түүхийн шинжлэх ухааны судалгаанд хавсрага ухаануудын орон зай ргөсөж, үүрэг зорилго нь нэмэгдсээр байгаа билээ. Үнэндээ түүхэн асуудлыг судлахдаа улс төрийн түүхийг судлахаас эрс шинэлэгээр сэтгэж, хавсрага ухаануудад хандах нь уйлын ач холбогдолтой билээ.

Түүхэн орон зай, цаг хугацаа түүний арга зүйг монголын түүхийн судалгаатай нягт холбон үзнээр манай орны түүх, соёлын талаар бодит байдалд тохирсон үнэн зөв дүгнэлт гаргалгаа эвшүүлэхэд өргөн боломжтой болж буйг тэмдэглэх нь зүйтэй.

Бид энэ өгүүлэлдээ билгийн тооллын гуравдугаар жарны улаан барс жил буюу 1206 оны амрын дэлгэр цагт Монголын тал нутагт болсон нэгэн түүхэн үйл явцын талаар товч тэмдэглэе. Чингэхийн тулд бид тухайн үйл явдлаас өмнө болж өнгөрсөн томоохон үйл явдлуудтай залгамж холбоотой авч үзэх нь зүйтэй байна.

НЭГ. 1189 оны Хар зүрхний Хөх нуурын Их хуралдай.

Түүний түүхэн ач холбогдол

Монголын нууц товчооны мэдээгээр, “Хамаг Монголыг Хабул хаан захирч байв” гэж өгүүлэн буй. Энэ бол тус улсыг байгуулан захирч явсныг баталж өгдөг. Академич Ч. Далай эн талаар “язгуурын Монголоос бүрэлдсэн гол улс XI зууны дунд үеэс нэгэнт байгуулагдаж эхэлсэн байжээ. Гурван голоор савласан тэрхүү язгуурын улс нь XI зууны сүүлч, XII зууны эхэн буюу Байшинхор догийн, Тумбанай сэцний үед Хамаг Монгол нэртэйгээ түүхэнд тодорхой болон гарч ирсэн байна.

Хавл Хамаг Монголын хаанд өргөмжлөгдсөн нь 1130 он болж таарч байна. Тэрээр наман жилийн хугацаанд Хамаг Монгол улсыг хүчтэй засаг төртэй, нэгдсэн хүчирхэг эрэгтэй болж чаджээ”/1/ хэмээн бичсэн нь дээрхи өгүүлэмжийг баталж байгаа юм.

Дэр өгүүлсэнчлэн Боржигин овогтон Боданчар богдоос эхлэн урт удаан хугацааны түүхэн ца үеийг өнгөрөөгөөд XI-XII зууны үест хүрээд Нирун Монгол ба Дарлигин Монгол ямгуудыг нийтэд нь багтаасан Хамаг Монгол Улсыг байгуулан Төв Азид хүчирхэгжин мандаад, Алтан улсын түрэмгийлэлийг тууштай эсэргүүцэн тэмцэж байсан байна. Хиаг Монгол хэмээх хүчирхэг улсыг Хабул /1101(30)-1137/, Амбагай /1137-1146/, Хотула /147- ?/, Тэмүжин /1189-1206/ зэрэг хаадуудтай байсан. Эдгээр дөрвөн хаадын дундаас урьд хожид төр барьсан Амбагай, Тэмүжин нарын үед Хамаг Монгол Улс ихэд хүчирхэгжин мандаж байжээ. Мөн түүнээс гадна Хотула хааны дараагаар 1150-аад оны сүүлчээс 171 он хүртэлх хугацаанд Хамаг Монгол Улсыг Есүхэй хэмээх арга ухаан, баатар бодлого хосолсон Боржигин овгийн дээдэс захирч байв. Тэрээр хэдийгээр хаан өргөмжлөгдсөн эсэх нь монголын түүх бичлэгт тодорхой тэмдэглэгдсэн зүйл алга байна.

Зарим судлаачид Есүхэй баатрыг “хаан” байсан гэж өгүүлсэн байдаг. Ямартай ч болов Тэмүжин-Чингис хааны эцэг Есүхэй нь өөрийн амьдарч байсан үедээ эгнэшгүй ухаан билэг хурц, зориг эрмэлзлэл төгс хүмүүн байсан нь тал нутгийн олон жилийн дайн самуун түр намжиж, ард иргэд энх амар сууж байснаас гадна түүний үр хүүхдүүд нь тэнгэрийн доорхид билэг авъяас, бодол санаагаараа онцгойрон манлайлан гарч ирсэнээс харж болох амой.

“Сүүдрээсээ өөр нөхөргүй, сүүлнээсээ өөр таиуургүй болон хоцорч Онон морний өгсөөж уруудан олирс, мойл, сөдөл, гичгэнэ, мангир, гогод түүн хүнсэлж суун атал хөвгүүд нь өсөн өндийж, загас шувуу гэхдөөж, тарвага зурам намнаж, эхээ тэжээж байжээ. Ийнхүү Есүхэй баатрын гэр бүл нэг хэсэг хугацаанд маш их ядуу зүдүү байдалд оршиж байжээ. Өүлэн хатан хэдий тийм ядуу зүдүү амьдарч байсан боловч хүүхдүүдээ жинхэнэ язгууртны ёсоор хүмүүжүүлэн өсгөсөн”/2/-өөр барахгүй хожим “Насанд хүрмэгц Тэмүжин өөрийн цаашдын хувь заяаны асуудлыг эргэцүүлэн бодож, эхийн заавар зөвлөгөөнөөр сурвалжит язгууртны байдлаа сэргээн, эрхээ эдэлж Хамаг Монголд байр сууриа бэхжүүлэхийг зорьжээ. Тэр цагт Тэмүжин Хамаг Монголын нэгдэлийг сэргээж хан болохыг бодсон эсэх нь тодорхойгүй боловч түүний бүх үйл ажиллагаа бодит агуулга чиглэлээрээ чухам тийм зорилтонд захирагдаж...”/3/ хагацсан улсаа хамтатгах, бутарсан улсаа бөөгнүүлэх үйл хэргээ бодитойгоор хэрэгжүүлж эхэлсэн байна.

Чингэхдээ Тэмүжин юуны урьд цэрэг-улс төрийн байр сууриа бэхжүүлж сүр хүч олохын тулд хүчирхэг Хэрэйдийн Тоорил хан, Жадараны Жамуха нартай эвсэл холбоо байгуулан тэдний ивээн тэтгэлэгийг олжээ. Дараа нь өөрт үнэнч нөхөд, баатар эрсийн шилэгдмэл хүчинг сонгон авахыг чухалчлав. Тэмүжин хүнийг анхнаас нь таньж олоод биедээ улам үнэнч болгон, тэнгэрийн төлөө ёсыг явуулахад юунаас ч буцахгүй тэдгээр нөхдийн бүлгэмээс нь урван тэрслэх явдал төдий л гардаггүй байсан. Энэ нь магадгүй Хамаг Монголын ханлигийг сэргээн босгож, Нэгдсэн Монгол улсыг байгуулахад сэтгэл зүйн үүднээс чухал дэмжлэг үзүүлсэн болой.

Тэмүжин Хамаг Монгол улсын хаан ширээнд өргөмжлөгдсөн нь дараахь хэдэн зүйлтэй холбоотой байна. Тодруулахул, НЭГД: Угсаа гарвалаараа /тэрбээр эртний язгуурт Боржигин овогтны хойчис/, ХОЁРТ: Удирдагчийн ёс суртахуунт чанараараа /сайхь хүмүүн эрдэм ухаан, авъяас чадвар олноос ялгаран гарч, Боржигин овогтноор өөрийгөө хүрээлүүлж чадсан/, ГУРАВТ: Нийгмийн сэтгэл зүйн асуудлыг урьдчилан таньж чадсанаараа /ард олны удаан хугацааны хагацал гуниг, бутрал бухимдалын уур амьсгал ихэд ширүүсч хүчээ нэгтгэх гэсэн нийтийн хүсэл эрмэлзлэл нь Хамаг Монгол улсыг дахин сэргээх гэсэн Тэмүжиний улс төрийн зориг эрмэлзлэлтэй яв цав нийцэж түүнийг нийтээр хүлээн авснаар барахгүй хойшид ч үргэлжлүүлэн толгойлж чадах тийм удирдагчийг ард олон Есүхэй баатрын ууган хүү Тэмүжинээр сонгосон/ амин холбоотой байсан бүлгээ.

Залуу манлайлагч “Тэмүжин Онон, Хэрлэнгийн эхэнд орших Цэнхэрийн голын Хар зүрхний Хөх нуур гэдэг газар буудаллан байхад Хотула хааны гуравдугаар хүү Алтан, Есүхэй баатрын ах Нэгүн тайжийн хөвгүүн Хучир, Жүрхэн аймгийн толгойлогч Охин бархагийн ач хүү Сача бэхи тэргүүтэй язгуурын Монголын нөлөө бүхий ноёдын онц их хуралдаан 1189 онд болж, Тэмүжинд Чингис хаан гэдэг цол өгч Хамаг Монгол улсын хаанд өргөмжилжээ”/4/. Чингэж Хабул, Амбагай, Хотула хаад болон Есүхэй баатар нараас хойш нилээд хугацаанд эзгийрч байсан Хамаг Монгол улсын хаан ширээ бүрэн эрхт эзэнтэй болж, дахин хүчирхэгжин мандаж даяар олны энх амар төрийн хэргийг эрхлэх ард олны хүсэл эрмэлзлэл, цог заль нэгэнт төгөлдөржжээ.

Мөн энэ талаар академич Н.Ишжамц нэгэн сэдэвт зохиолдоо: “Ямар боловч Тэмүжин Онон, Хэрлэний Монголчуудын олонхийг захиргаандаа нэгтгэн Хамаг Монголын ханлигийн нэгдлийг сэргээжээ. Язгуурын Монгол, Тайчуудын ихэнх хэсэг нь Жамухын мэдэлд үлдсэн ч гэсэн Хамаг Монголын ханлигийг хагас эрэмдэг атугай ч албан ёсоор сэргээсэн нь цаашид Монголын нэгдсэн төр байгуулагдахын улс төрийн чухал урьдчилсан

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

нөхцөл болж, эх үүсвэрийг тавьж өгсөн гэвэл зохино”/5/ гэж дүгнэсэн нь өнөө ч эрдэм шинжилгээний ач холбогдолоо алдаагүй байна.

1189 оны Хар Зүрхэний Хөх нуурын нутагт болсон Их хуралдай нь тархай бутархай оршин тогтнож байсан язгуурын монгол аймгуудын нэгдэл болох Хамаг Монгол улсыг сэргэн мандсаныг зарлан тунхаглаж, цаашдаа Монгол туургатны нэгдсэн тулгар төр бүрэлдэн тогтох нийгэм-улс төр, соёл зан суртахуун, оюун санааны дэвшилт нөхцөлийг бий болгож өгсөн амой.

Ийнхүү Монголд феодалын нэгдсэн төр байгуулагдах түүхэн бодит нөхцөл бүрдсэн учир феодалжин буй язгууртан нарын эрх ашгийг илэрхийлж, нэгдмэл төр байгуулах үйл явцыг хэрэгжүүлэн биелүүлэхэд хүчин зүтгэх хүмүүс зайлшгүй гарч ирэх ёстой байсан юм. Язгууртны сонирхолыг илэрхийлж тийнхүү гарч ирэгсдийг нэгтгэсэн хүчин бол Тэмүжиний удирдлагаар дахин сэргэсэн Хамаг Монгол улс байсан бүлгээ.

ХОЁР. 1206 оны Их Хуралдай чуулах болсон урьдчилсан нөхцөл

XII зууны сүүлийн хагаст буй болсон язгууртны хоорондын зөрчил тэмцэл нь юуны урьд эдийн засгийн үе шаттай тэмцэл байсан хэмээн зарим судлаачдын бүтээлд тэмдэглэгджээ. Тэд бэлчээр, мал сүрэг, харьяалах боолоо худалдан харилцан дайтах, худалдааны замын төлөө өрсөлдөөнд өөрийн эрхгүй татагдан орсоор байлаа.

Монголын нийгэмд үүссэн нийгмийн шинэ харилцаа тус орны үйлдвэрлэх хүчний хөгжилд түлхэц болж, улмаар Монголын ханлиг аймгуудын хооронд эдийн засгийн сүлжээ тогтох үйл явцыг түргэсгэн өгч байжээ. Чухамхүү Монголын язгууртан хоорондын тэмцэл тулаан, салан тусгаарлах үзэл нь тэр цагийн аймгуудын биеэ даан улс төрийн талаар тусгаар тогтнох явдалд асар их бэрхшээлийг учруулж байсныг сурвалжийн мэдээнээс тодхон харагдана.

XI зууны сүүлийн хагаст Монголын дээд язгууртнуудын их зонхи нь нэгэн утгаар нүүдэлч-малчин түмнээ эзэрхэн захирах явдлаа бэхжүүлэх цаашлаад эсгий туургатныг нэгтгэх; нөгөө талаар харийн эрхшээлээс ангижирч, биеэ даан оршин улмаар гадны түрэмгийлэлд шийдвэртэй цохилт өгч, дайныг зохион байгуулалттай хийхийн тулд нэгэн хүчирхэг хааны захиргаан дор хүчээ нэгтгэхийг аяндаа эрмэлзэх болжээ. Тэдгээр дээд ангийн эрх ашгийг хамгаалсан нэгдмэл засаг төр байгуулагдах эдийн засаг, улс төрийн нөхцөлүүд бий болж эхэлсэн юм.

Энэ тухай “Монгол Улсын түүх” зохиолын гуравдугаар ботид бичихдээ: “Монголын бүх газар нутаг дэвсгэр нэгдэж, монгол угсаатны нэгэн нэгдмэл улсын хүрээнд багтах түүхэн хэрэг явдал бол монголын улс аймгийн язгууртнуудын хооронд урт удаан хугацаагаар үргэлжилсэн өрсөлдөөн тэмцэлдээний үр дүнд Хамаг Монголын Тэмүжин тэргүүтэй язгууртны бүлэглэл нь хуучин аймгийн нэгдлүүд, улс ханлигуудыг удаа дараалан цохин дийлсээр ялан гарч” /6/ ирсэн нь түүхэн үнэн болой.

XII зууны сүүл үеийн нүүдэлчин аймгууд нь нийгмийнхээ хөгжлийн хувьд нэгдмэл байгаагүйг бид мэднэ. Тодруулбал, XIY зууны Персийн сударч Рашид Ад Дин, Оросын нэрт монголч эрдэмтэн В.Я.Владимерцов нарын бүтээлд “ойн ард”, “талын нүүдэлчид” гэсэн хоёр хэсэгт хуваагдаж байсныг тэмдэглэжээ. Тэдний хөгжлийн түвшин харилцан адилгүй байснаас гадна “ойн ард” нь загасчид, анчид харин “талын нүүдэлчид” нь мал аж ахуй эрхлэн амьдрагсад багтаж байлаа.

Доктор Н.Ням-Осорын нэгэн бүтээлд: “Тэрхүү нүүдэлчин малчид буюу нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг хүмүүс нь монголчуудын их зонхи нь байж ахуй амьдралд зонхилох үүрэг гүйцэтгэж байлаа” /7/ гэсэнтэй бид санал нийлж байгаа билээ. Тэрхүү нүүдэлчид дотроос томоохон аймгууд гэвэл Хамаг Монгол, Найман, Мэргэд, Хэрэйд, Татаар нар байв. Тэд голдуу Гурван мөрний хөндий, Сэлэнгийн сав нутгуудад өвсний соргог, усны тунгалагийг сонгон нүүдэллэн амьдарч байв.

Харин *“Ойн аймгууд буюу загасчид, булгачид нь гол мөрнүүдийн сав нутгаар, ой хөвчийн нутгаар суурьшин амьдарч байлаа. Байгалийн чанад хавиар Хори, Баргууд, Түмэд, Булгачин, Хэрэмчин, Урианхай нар, Тэлэнгүд аймгийнхан амьдарч байсан”/8/* ажээ. XII-XIII зууны Монголын томоохон овог аймгуудын байдал ерөнхийдөө дээрх мэт байжээ.

Академич В.Я.Владимерцовын судалгаанд дээрх ойн ба талын монголчуудын нийгмийн амьдралын талаар цааш өгүүлэхдээ: *“Хүй нэгдэл задарч, ангийн ялгаа идэвхжихийн хэрээр урьдын адил отог овгоороо нүүдэллэх бус харин хэсэг айл өрх болон тус тусдаа нүүдэллэх болсон байна. Эцгийн эрхт ёст феодалын шинэ харилцаа бий болсон нөхцөл байдалд энэхүү өрх айлаараа нүүдэллэх нь хүрээгээр нүүдэллэхээс илүү зохимжтой байсан агаад аж ахуй эрхлэлт нь ч илүү тохиромжтой байсан”/9/* нь овгийн харицаанаас дараагийн шатанд ороход дэмжлэг үзүүлжээ. Үүнээс гадна, *“Энэ үеийн нэг онцлог бол ангиудын ялгарал улам хүчтэй болж ноёд язгууртнуудын хүчирхэг анги биеэ даан гарч ирсэн явдал бөгөөд эл анги хуучин байдлаараа өөрийн эрх дархыг хамгаалан бэхжүүлж чадахгүй байсны учир төр хэмээх хүчтэй аппараттай болох шаардлага гарч ирэв”/10/* хэмээн доктор Н.Ням-Осор чухал санаа дэвшүүлжээ.

XII сүүлч, XIII зууны эхээр монголчуудын нийгмийн бүлэг, хүн амын бүтцэд ихээхэн өөрчлөлт гарчээ. Овгийн ахлагч, аймгийн хан тэдний ойр төрлийнхөн хүн амын тогтвортой бүлэг болж ноёрхох байр суурь эзэлж язгууртны шинэ шинж төрх илэрч эхэлсэн байна. Мөн тэдний холбоотон болж бие даан амьдрах чадвар, мал хөрөнгө ихтэй чинээлэг гэр бүлүүд эрс нэмэгдсэн бөгөөд “сул ард”, “чөлөөт иргэд”, “чинээлэг иргэд”, “залуус”, “урт дурын хүмүүс” гэх зэргээр түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Гэвч тэд нийгмийн шинж төрхөөрөө хүн амын нэгэн өвөрмөц бүлгийг бүрдүүлж, өөрийн гэсэн байр суурь бүхий бие даан нүүдэллэн амьдрах айлын эзэд, олон малтай болж хөрөнгөжин буй чадварлаг хүмүүс байсныг судлаачид цөөнгүй тэмдэглэсэн байдаг.

Овог аймгийн жирийн чөлөөт хүмүүс болох иргэдийн нэг хэсэг нь өөрийн овог аймгийн язгууртан нарын ивээлд орж, тэдэнд захирагдан үйлчилж байхад нөгөө хэсэг нь дээрх язгууртнуудад захирагдахгүйгээр бие даан амьдрахыг эрмэлзэж байлаа. Мөн “боолчууд” хэмээн нэрлэгдэж байсан зарцлагдах хэлбэрээр амь зуух болсон ядуу өрхийн хүмүүс өөр нэгэн өвөрмөц давхраа болж хүн амын доод хэсгийг бүрдүүлж иржээ.

Монгол нутагт оршиж байсан нийт аймаг, ханлигуудын хөгжлийн хязгаар, улс төр-аж ахуй болон зан заншил-нийгмийн сэтгэлзүйн орчин тус бүрдээ онцлогтой байсан боовч бүх Монгол угсаатны нийгмийн хөгжлийн байдалд хэд хэдэн шинэ хүчин зүйл илрэн тэдгээрийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж байв.

XII-XIII зууны үеийн монголчуудын түүхийг ойлгохын тулд Төв Азид угсаатнуудыг хоёрдмол утгатайгаар өөрөөр хэлбэл, нэгд:овог аймаг мэт угсааны бүлгийн өөрийнх нь шууд нэр маягаар; хоёр: харь гаралтай овог аймгууд бүрэлдэхүүнд нь орсон байлаа ч гэсэн соёлын болон улс төрийн тодорхой иж бүрдэл болж байгаа хэсэг бүлэг овог аймгуудыг хамтад нь ерөнхийлөн нэрлэж байсан гэж хятадын судлаачид судлаачид үзжээ.

Монголын нүүдэлчин малчин аймгуудын гол баялаг нь хонь, ямаа, адуу, үхэр зарим аймаг тухайлбал, Найманчууд тэмээ тэжээдэг байв. Мал аж ахуйд хонин сүрэг гол үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд хонины мах, арьс нэхий, үс ноос, сүү нь монголчуудын дотоодын үндсэн хэрэгцээг хангаж байсны сацуу зэргэлдээ орших суурин иргэншилт ардууд эн тэргүүнд Хятадын Сүн /960-1279 он/, Цинь /1115-1234 он/ улсын зах зээлд гаргадаг байжээ.

Эсгий туургатны ахуй амьдралд адуун сүрэг ялангуяа сайн морьдын гүйцэтгэж байсан үүргийн талаар XIII зууны үед монголоор жуулчилсан Хятадын жуулчин Чжао Хуний тэмдэглэлд: *“Татаарчууд эмээл дээр хүлэг мориныхоо зоон дээр төрж өсдөг. Тэдний амьдрал бүхэлдээ жилийн дөрвөн улиралын турш ан авын ажил дунд өнгөрдөг болохоор байлдаан тулаанд аяндаа суралцана”/11/* хэмээх амуй. Тэдгээр малчин аймгууд аж ахуйгаа эрхлэн хөтлөхийн тулд нутаг бэлчээр сонгон дагаж байнгын нүүдэллэх боловч

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

өвөлжөө болон зуслан нь тодорхой нэгэн нутагт байжээ. Монголчууд хүрээ хүрээгээр нүүдэллэх бөгөөд түүнд 1000 орчим өрх буюу мухлагт тэрэг багтдаг байв. Тэд ч үүндээ үнэхээр сайндадсан ажээ.

Нийгм-улс төрийн амьдрал төлөвшин тогтож, аж ахуй эдийн засгийн хувьд бусадтай чөөтэй харилцах болсон нь Монгол овог аймгийн бутралыг эцэслэхийн тулд XII зууны эцс, XIII зууны эхний жилүүдэд Чингис хаан болон түүний шадар туслахуудын дайчин цогтй тэмцэлийн ялалтад бодит нөлөө үзүүлж, Монголын нэгдсэн төр байгуулах бэлтгэл ажи бүрнээ хангагдсан болохыг илтгэж өгсөн байна.

ГУРАВ. Их Монгол Улсыг зарлан тунхагласан нь

1206 он гармагц Монголын бүх ханлиг аймгууд Тэмүжиний захиргаанд орж, Хамаг Монголын хнлигийн мэдэлд нэгдсэн байна. Бүх Монголыг нэгтгэж, Монгол үндэстний нэгдсэн тулр төрийг байгуулах бололцоо хэдийнэ бүрдсэн байв.

XIII зууны эхэн үеэс дэлхий дахины анхааралыг Ази тив түүний дотор Төв Ази өөрийн эрхгй татав. Тухайн үеийн түүхийн мэдээ сэлтийг үндэслэвэл, XIII зуун дөнгөж эхэлж байхад тохиолдсон улаан барс жилд Монголын тал нутагт урин дулаавтар хавар болж, урьд уьдынхаас илүү хүн малын зоо тэнийж, мал сүрэг эрт ногоонд цадсан байжээ. Хаад ноёдос аваад харц доодсоо хүртэл бүгд өнгө жавхаатай, айл болгонд хаан Тэмүжиний өгс авъяас, эр зориг, ид шидийг л магтан дуулсан яриа хөөрөө түгэн дэлгэрч байсан нь XII зууны үед үүсч өнөө хэр уламжлагдан үлдэж хоцорсон ардын аман домгоос тодорхой хаагддаг бүлгээ.

Билгйн тоололын гуравдугаар жарны улаан барс жилийн намар эсгий туургатны нүүдэлчин үдэстэний тулгар төрөө энхжүүлэн тогтоосон Чингис тэргүүтэй баатар эрсийн “авъяас чавар” нь тухайн цаг үеийнхээ эсгий туургатныг гийгүүлж чадсан үлэмжийн төгс үйл бөөд олон зуун жилийн турш тархай бутархай оршиж байнгын дайн тулаанд зовж туйлден нүүдэлчин угсаатан бүрэлдэн тогтож, Их хэрмээс Байгаль далай хүртэлх нүүдэлчин үдэстний нийгмийн хөгжилт, дэвшилийн шинэ эрин үеийн хөшгийг татсан алс хэтийн үзмж ач холбогдолтой түүхэн үйл явц эрчимтэй явагджээ.

“1206 он бол 800 орчим жилийн тэртээ талын язгууртнуудын Их Хуралдай чуулж, язгуур Монголчуудын нэгдэн хүчирхэгжих их хэргийг орь залуугаасаа 20 гаруй жил оройлон малайлж, эр тавирсан 45 насандаа бодит биелэл болгосон Тэмүжинг шинэ тулгар нэгдэн Их Монгол Улсын хаан ширээнд нэгэн дуугаар өргөмжилсөн”/12/ түүхэн цаг үе билэ. Мөн үүнээс гадна судлаачид: “1206 онд хоёр удаа Их хуралдай чуулж байсан” гэхболовч чухам хэзээ болсон бэ? Их Монгол улсыг тунхагласан хуралдайн өмнө үү? Драа нь уу? гэдэг нь тун бүдэг, тодорхойгүй байна. Бидний дэвшүүлэх санал бол 1206 оны намрын дунд сараас хойш хоёрдахь Их хуралдай болсон гэж үзэх зүйтэй байна. Энэ ухайд Зөвлөлтийн /хуучнаар/ эрдэмтэн Е.Н.Кычановын нэгэн өгүүлэлдээ: “Чингис хан 1206 оны хуралдайн дараа өөрийгөө зүрчидийн хараат болохыг эс зөвшөөрөн араа нь Алтан улстай харилцаагаа тасалсан нь тэднийг ихэд айлган сандаргажээ. Тангудууд идэвхгүй байсан явдал Чингисийг зоригжуулж зөвхөн Си Ся /Баруун Ся/ууу Тангуд улс 1038-1227 он.Г.С./ төдий биш, бас гол дайсан зүрчидтэй дайнд бэлтгэхэд хүргэжээ”/13/ хэмээн бичсэнийг тодотгомоор байна. Дээр өгүүлсэн зүйлсийг 126 оны хоёрдахь Их хуралдайгаар хэлэлцсэн нь тодорхой юм. Учир нь, Их хуралдайгаа “шинэ хааныг сонгох, төр улсын тулгамдсан чухал асуудалд оновчтой хариу эрэлхийлж, нягтлан магадласаны үндсэн дээр их хаанд зөвлөх үүрэг бүхий” эрх хүлээдэг басан бүлгээ. Мөн үүнээс гадна, “...Түвэд улс, Зүүн хойд Азийн олон улсын тавцан дээ Монгол улс хэмээх шинэ хүчин гарч ирсэн чимээг сонсоод 1206-1207 оны хооронд хоё удаа элч илгээж найрамдалт харилцаа тогтоох ба өмгөөлөл эрсэнд Чингис хаан санал нь соёрхож өмгөөлөлдөө авсан бөгөөд үүнд нь талархсан түвдийн Магэр гурван муж наян найман түмэн Хар Түвд улс дагаар оржээ”/14/ гэжээ. Сүүлд тэмдэглэсэнхоёр зүйлээс ажиглахул, 1206 оны намрын эхэн сард болсон анхны Их

Хуралдайгаар олон жилийн өвөр зуураа тэмцэлдсэн дайн самууныг эцэслэн Их Монгол улсыг тунхаглан зарлаж, Тэмүжинг Их хаанаар өргөмжилсөн зэрэг хавтсан үүдтэний төр ёсны чанартай, үлэмж нарийн үйл хэргийг хэлэлцсэн байхад; түүний дараахан буюу намрын дунд сараас хойш болсон *хоёрдахь удаагийн Их хуралдайгаар* эртний өст Зүрчидийн Алтан улсаас улс төр, эдийн засгийн харилцаагаа бүр мөсөн тасалж, тэр ч бүү хэл эцэг өвгөдийн өшөөг авахын тулд тэдэнтэй дайтах, чингэхийн учир хөрш зэргэлдээ Онгууд, Тангуд, Түвэд орныг дагаар оруулан авч Алтан улстай хийх дайндаа нэгэн гар болгох гэх мэт улсынхаа үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын шинэ чиг баримжааг бататган хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцсэн гэж үзвэл зүйтэй байна.

Тэнгэр газрын савсалганд “Монгол” хэмээх нэр Эргүнэ хунгаас салбарлан гарсан Төв Азийн тал нутгийн нүүдэлчин аймгуудын хүчин чадал тийм ч дорвитой байсангүй боловч **Их Монгол Улс** хэмээх нэр нүүдэлчин үндэстний ерөнхий нэр болж, түүхийн тавцнаа асар хурдтайгаар цуурайтаж эхэлсэн болой.

Чухам энэ үеэс л Азийн цээжнээ эсгий гэрт сууж, эрэмгий хүлгийн нуруун дээр амьдарч, эр чадлаараа шалгаран байгаль газарзүйн онцгой орчиндоо дасан зохицсон бие жижиг морь унасан Монгол дайчид цагаан шонхор сүлдээ шигтгэсэн хөх тугаа намируулж, нар мандах зүүн зүгээс нар жаргах баруун зүг хүртэлх “**харийг эзлэн, хамгийг өргөтгөж**” хүчирхэгжин мандаж агсан үндэстэн маань өнөөгийн цагт тэнгэрийн доорх хэн бүхний анхаарлыг татах болов.

Хэнтий Хан уулын салбар Бурхан халдунаас ундарсан Онон мөрний тэргүүнээ Дэлүүн болдог дахь алтан хөвөө хөх хөндийгөөр чимсэн Чингис хааны цасан цагаан ордны дэргэд алтан ургийнхан, есөн өрлөг сайд, олон гавъяат түшмэл, харц ард есөн хөлт цагаан туг, дөрвөн хөлт хар сүлдээ тэнгэр хэмээх уудам орон зайд даяар мандуулж, Хөх Монголчуудын анхдагч нэгдэлийг баяр найрын дунд дурсан өгүүлэх, Их Хуралдай дээр тэнгэрлиг хөвгүүн Тэмүжин дээд төрийн Бөөгийн шашны ёс журмаар нар гарах өмнө зүгийн тэнгэр дуудаж, сууринд суумагц, уйгар гаралтай бичгийн их түшмэл, улсын багш Тататунгаа Чингис хаанд есөнтэй мөргөж, “*мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсын далай хааны зарлиг ил болгон дор хүрвээс биширтүгэй, айтугай*” хэмээх үсэгт цагаан хас тамгыг өргөжээ. Энэ бол эрт үед “*тамга*” хэмээх төрийн дээд билэгдлийг хэрэглэж байсны анхны түүхэн баримт болно.

Түүхэнд тодоор тэмдэглэгдсэн 1206 оны Их Хуралдайг судлаачдийн тэмдэглэсэнчлэн: “*эл хуралдай монголчууд нийлж нэгдэн, их улс болсон үйл явцыг илтгэн харуулах түүхэн том үйл явдал*”/15/ байсан нь тус онд болж өнгөрсөн түүхэн үйл явцын үнэ цэнэ дэвшилт шинж чанарыг чухалчлан өгүүлжээ.

Ингээд бид асуудлыг тодорхой болгохын үүднээс 1206 оны анхны Их хуралдайгаар Их Монгол улсыг тунхаглан зарласаны дараагаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дотор нь бага зэрэг задлан өгүүлсү.

Улс төр, төрийн байгуулалын талаар: Зүй нь, Тэмүжин Чингис хааны үүсгэн байгуулж, 1206-1260 оны хооронд цэцэглэн мандаж байсан төрийн нэр болох “Их Монгол Улс”-ийн талаар тодруулан үзмээр байна.

Монголын болон гадаадын эрдэмтэд дурьдан буй төр улсыг “нэгдсэн улс”, “Их Монгол улс”, “гүрэн улс”, “эзэнт улс”, “эзэнт гүрэн”, “тулгар улс”, “тулгар төр”, “Бэта улс”, “Чингисийн хаант улс”, “нэгдсэн тулгар төр” гэх зэргээр олон янзаар тайлбарлан бичсэн байдаг.

Хэдийгээр гадаад, дотоодын олонх эрдэмтэд дээр өгүүлсэн асуудалд ерөнхийдөө “Их Монгол Улс” гэдэг санал дээр нэгддэг боловч тус үгийн агуулга, утга санаа нь хэд хэдэн зүйлээр тайлбарладаг. Үүнийг үзэхүл, академич Ш.Бира тэмдэглэхдээ: “*Их Монгол Улс хэмээх нэрэнд буй “Их” гэдэг үг бол монголын улсын хэмжээ хязгаарыг заахаас илүү Чингисийн Алтан ургийнханд болон Чингисийн анд нөхөддөө хувиарлан өгсөн хувь улс-аас гол улс-аа ялгаварлахын тулд ийнхүү нэрлэж байсан байж болох талтай. Чингис хааны хувьд Улс нь “хувь иргэн” мөн “иргэн улс” буюу Монголын их хаанд харъяалагдах Их Улс*

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

хэмээсэн хоёр үндсэн утгатайн хэрэглэгдээж байсан талаар В.Я.Владимерцов гярхай ажиглан тэмдэглэсэн байдаг” /16/ гэж бичсэнтэй санал нэг байна. Мөн 1206 оны Их хуралдайгаар монгол угсаатны олон овог аймгуудын удаан хугацааны хагацал, учиг самууныг төгсгөл болгож эсгий туургатаны анхны **Их төр**-ийг байгуулсан нийгэм-улс төрийн хийгээд түүхийн нөхцөл байдал хэрхэн нөлөөлсөнийг анхааран үзэх хэрэгтэй бүлгээ.

Ингээд бид асуудлыг тодорхой болгохын үүднээс 1206 оны анхны Их хуралдайгаар Их Монгол улсыг тунхаглан зарласны дараагаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дотор нь бага зэрэг задлан өгүүлсү.

Чингис хаан Их Монгол улсын хаан ширээнд суусны дараа өөрийн хураан цуглуулсан улсынхаа төрийн байгууламжийг дахин шинэчлэн зохион байгуулж, олон ноёдод зэрэг хэргэм соёрхон албан тушаалд томилжээ. Мөн тэр жил эсгий туургатны язгууртнуудын Их Хуралдай дээр Чингис хааны их үйл хэрэгт нь амь хайргүй зүтгэж, тал нутгийн баатар эрсийн цэгц журмаар хүчээ өргөсөн нэг Улсын ван /Жалайрын Мухулай/, нэг улсын их заргач /Татарын Шихихутуг/, хоёр манлай /Уруудын Зүрчидэй, Мангуудын Хуйлдар/, дөрвөн хүлэг /Боорчи, Мухулай, Борохул, Чулуун/, дөрвөн ноход /Зэв, Хубилай, Зэлмэ, Сүбэдэй/, дөрвөн дархад /Борохул, Сорхон шар, Бадай, Хишлэг/, дөрвөн чэрби /Дадой, Доголху, Толун, Өүлэн/, наян найман гавъяат, ерэн таван мянгатын ноёд зэрэг дээд доод ялгалгүй хишиг шан хүртээж, эзэмшил нутаг олгосон нь феодалын эзэд, газрын томоохон эзэд бий болох нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

БНХАУ-ын эрдэмтэн Сайшаал “Чингис хааны товчоон” хэмээх хоёр боть зохиолдоо Чингис хааны өөрийнх нь итгэл найдвартай түших гол хүчингүй бол бүх үндэстнийг нэгтгэж ч чадахгүй, зохион байгуулж ч чадахгүй байсан гэж үзээд Чингис хаан дэргэдээ ийм “түшилгэ хүч” /тулгуур хүчин.Г.С./-ийг бүрэлдүүлж чадсаныг бичжээ. “Энэ нь Чингисийн “дөрвөн хошууч”, “дөрвөн хүлэг”, “хоёр манлай”, “есөн өрлөг”, наян найман гавъяатнаар гол болгосон “нөхөр бүлгэм”, хишигтэнээр гол болгосон “шадар зэвсэгт бүлгэм” ба дотоод хуралдайгаар бүрэлдсэн “бодолгоч бүлгэм” эсвэл “зөвлөгч бүлгэм” нь болой”/17/ гэж бичжээ. Энэ нь зохиогчийн хэлэхээр, “түүх шастир ба шүүмжлэл үгүүлэлд хэдийбээр ингэж тодорхой дурьдаагүй ч ийм учир хэрэг бүр байсан” гэж өгүүлсэн нь судлуустай зүйл байна.

Мөн үүнээс гадна БНХАУ-ын судлаач Чигэ шинэ тулгар Их Монгол Улсын төрийн алба хашигчдын нэр, тушаалын талаар тун сонирхолтой зүйлийг бичжээ. Түүнийг дор сийрүүлбээс:

1. Улсын ав хомрогын явдлын ерөнхий захирагч ноёны тушаалд Зүчийг томилов.
2. Улсын засаг хуулийн явдлын ерөнхий захирагч ноёны тушаалд Цагадайг томилов.
3. Улсын аливаа оюун ухаан арга бодлого гаргах явдлыг хариуцах хаан төрийн засагчийн тушаалд Өгэдэйг томилов.
4. Улсын цэргийн зохион байгуулалт ба цэргийн зэр зэвсгийн явдлын ерөнхий захирагчийн тушаалд Тулуйг томилов.
5. Улсын их заргач ноёны тушаалд Шихихутугийг томилов.
6. Улсын бүгдийн дээр сууринд сууж, хааныг хавсран төрийн их хэргийг шийдвэрлэгч ноёны тушаалд Боорчи болон Мухулай нарыг томилов.
7. Улсын үйл бүхнийг ахлагчийн тушаалд Хубилайг томилов.
8. Улсын баруун гарын Алтай орчмын түмний ноёны тушаалд Боорчийг томилов.
9. Улсын зүүн гарын Харагун Жидун орчмын түмний ноёны тушаалд Мухулайг томилов.
10. Улсын төвийн түмний ноёны тушаалд Наяаг томилов.
11. Улсын Эрчис мөрний орчмын ойн иргэдийн түмний ноёны тушаалд Хорчийг томилов.

12. Зүчийн доорх түмний ноёны тушаалд Хунанг томилов.
13. Улсын шаагин суртахууныг хамаарах Бэхи ноёны тушаалд Үсүн өвгөнийг томилов.
14. Улсын аливаа бичиг явуулах, язгууртны хүүхдүүдэд багш болох бичээч, тамгачийн тушаалд Тататунгааг томилов.
15. Улсын үзсэнийг үл нуун, сонсоноо үл хавчих дөрвөн зөвлөгчийн тушаалд Хунан, Хөхчүс, Дэгэй, Үсүн өвгөнийг томилов.
16. Хааны ордны буурч ноёны тушаалд Үнгүрийг томилов “/18/ гэж бичжээ. Энэ нь өнөө цагийн Засгийн Газрын танхимийн шинжийг зарим талаар агуулж байсан байна.

Хууль цаазны талаар: Чингис хааны билэг сургаал, захиа зарлиг, дүрэм сахилга, хувь соёрхолыг улсын заргач ноён татаар гаралтай Шихихутаг **Хөх дэвтэр** дээр уйгаржин үсгээр тэмдэглэж, Монгол үндэстний анхдагч үсэг бичигт Их Монгол улсын хууль-**Их засаг** хэмээн тунхаглан, урагын урагт хүртэл хэн ч бүү өөрчилсүгэй хэмээн тогтсон. Энэ хуулиар овгийн харилцааны дүрмийг орлуулж, хүмүүсийн үйл хөдлөл, үзэл санааг хууль зүйн үүднээс хязгаарлаж өгсөн байна.

Нүүдэлчин монголчуудын эрх зүйн боловсролын том баталгаа болсон “Их Засаг” хууль нь хааны нэг зарлигаар, ганц далайлтаар шууд буй болсон хэмээн үзвэл маш том эндүүрэл болно. Чухамдаа Чингис хаан Монгол овог аймгуудыг нэгдсэн нэгэн Их эзэнт гүрэн болгох үйл явц дунд түүнийг дагалдан аажмаар бүрэлдэн хэлбэршсэн хэмээн судлаачдын тэмдэглэсэн байдаг нь зүйтэй юм.

Чингис хаан дээрх ёс заншлаас гадна тухайн цаг үеийн түүхэн нөхцөл байдал, шаардлагын дагуу зохих зүйл заалтыг уудам тал нутаг мэт бодолдоо цэгцрүүлж, исгэрэх сум мэт ухаанаасаа уудалж гаргасан нь мэдээж амой. Үүнээс ажиглахул, уламжлалт ёс заншил хийгээд цагийн байдал түүхийн хүлээцийн шалгуураар шигшигдэн шүүгдсэн зүйлс нэгэн бүхэл цогц болж “**Их Засаг**” хуулийн анхны эхийг цаасан дээр дардастай, цадиг түүхэнд нэртэй болсон хэмээхүй.

1206 оны Их хуралдайн үеэр Их Засаг хуулийг олонд хэрхэн зарласан талаар Оросын судлаач В. Череванскийн тэмдэглэсэнээр: “*Тэмүжин хаан ширээнээсээ дохио өгмөгц асрын гүнээс Их засаг хуулийг бичсэн самбаруудыг урьд нь явах бөмбөрчдийн араас аван гарч ирэв. Ордны уйгар эрдэмтэд эдгээр самбарт бичигдсэн заалтуудыг чанга дуугаар уншиж сонсгох бөгөөд бөмбөрцгийн дуун хуралдагчдийн анхаарлыг түүнд хандуулах аж*” /19/ хэмээн бичжээ. Зохиогч эзэн Чингис хаан уг хуулиа ард олондоо зарлан тунхаглаж байх түүхэн цаг үеийн байдлыг тун сонирхолтой сэргээн бичихийг оролджээ. Мөн тус хуулийг зарлан тунхагласны дараагаар түүнийг дагаж мөрдөх ажлийг хариуцах хянах ноёноор өөрийн өргөмөл дүү Шихихутугыг сонгож, бүх улсын доторх хулгайг цээрлүүлж худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж байх Улсын дээд заргачаар томилсон буй. Энэ нь овгийн ахлагч шүүгч болдог байсныг хааны томилсон тусгай хүн гүйцэтгэдэг болсон буюу урьдын олон нийтийн шинжтэй байсан шүүхийн үүрэг хариуцлагыг улсын, төрийн нэрийн өмнөөс хүндэтгэлтэйгээр гүйцэтгэх үүрэг бүхий шүүх болгон өнөө цагийн Улсын дээд шүүгчийн тушаалтанг бий болгосон нь хүлэг морины дэл дээр хураан тогтоосон төр улсыг хууль цаазын хүчээр засан тохинуулах чухал үйл хэргийн эхлэл байв.

Засаг захиргааны зохион байгуулалтын талаар: Их Монгол улсыг байгуулахад Чингис хаан угийн овгийн зохион байгуулалтыг бүр мөсөн өөрчилж улсаа аравт, зуут, мянгат, түмт хэмээх эртний Хүннү гүрнээс улбаатай нүүдэлчдийн цэрэг-иргэний захиргааны зохион байгуулалтыг өөрийн шинэ тулгар улсынхаа улс төр, ахуй соёлын байдалтайгаа уялдуулсан байдгаараа өвөрмөц онцлогтой. Түүний шат бүр энгийн цагт засаг захиргааны тушаалыг хэрэгжүүлэх ба дайн тулааны түгшүүрт үед өөрийн харъяат нараа дайчлан байлдаанд ордог. Чингис хаан өөрийн бүх иргэдээ цэрэгжүүлсэн зохион

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

байгуулалтанд оруулж, түүнийгээ тухайн цаг үеэсээ хэтийдсэн нэн чадварлаг үндэсний армийг байгуулах нөхцөлийг бүрнээ хангажээ.

Өдөр шөнийн алинд боловч эзэн хааныг хамгаалан явдаг “далан турхаг”, “наян хэвтүүл”-тэй хишигтэн цэргийг “дархлах дүрэм” бүхий түмэн хишигтэн болгон цэгцлэн өргөтгөж, хаан улсынхаа тулгуур зэвсэгт хүчинг байгуулав. Энэ бол язгуур ураг төрлийн эрэмгий баатруудын үр ач нараас бүрэлдсэн Монгол үндэстэний анхдагч байнгын армийн цэрэг болох бөгөөд шинэ тулгар байгуулагдсан Монгол гүрний нэгдэл бэхжилт, нутаг дэвсгэрээ өргөтгөхөд ихээхэн үүрэг хүлээсэн морьт цэргийн гол бүрэлдэхүүн болж оролцжээ.

Ийнхүү Чингис хаан түмэн хишигтэнээ шөнийн манаач 1000 хэвтүүл, хор агсагч 1000 хорчин, өдрийн харуул 8000 турхагууд гэж хуваажээ. 1000 хэвтүүлийг их нөхөр Боорчоор ахлуулж, 1000 хорчинг дөрвөн хэсэг хуваан хэсэг тус бүрт ахлагч томилж Есөнтэгү, Бөхэй, Орхутаг, Лаблага нараар ахлуулах ба тэднийг ерөнхийд нь Зэлмэ жанжны хүү Есөнтэгүгээр захируулав. 8000 турхагийг бас мянганы нэгжээр хувааж, мянган бүрт мөн дарга томилсон байна. Энэхүү 8000 турхагуудын ахлагчийг БНХАУ-ын судлаач Чигэ бичжээ. Үүнд:

“Нэгдүгээр мянганы ахлагч Боорчийн ургийн Өүлэн чэрби

Хоёрдугаар мянганы ахлагч Мухулайн ургийн Буха

Гуравдугаар мянганы ноёноор Илүхэйгийн ургийн Алчидай

Дөрөвдүгээр мянганы ахлагчаар Додай чэрби

Тавдугаар мянганы ахлагч Доголху чэрби

Зургаадугаар мянганы ахлагч Зүрчидэйн ургийн Чанай

Долдугаар мянганы ноёноор Алчигийн ургийн Ахудай

Наймдугаар мянган бол Архай Хасараар ахлуулсан мянган баатрууд болно”/20/ гэх мэт өгүүлсэн байна.

Цусан эрлийн овгийн харилцаа давамгайлсан нийгмийн хөгжлөөс туйлбартай ангижирч, өрө нутгаар суурилсан цэрэг-засаг захиргааны нэгдсэн шинжтэй мянгатын байгууламжийг тогтоон амжилттай хэрэгжүүлсэн нь нэгэн чухал үйл ажиллагаа байв. Хаант улсын хэмжээнд гурван мянгат байгуулагдаж, тэр нь дотроо ерэн таван мянгатад, тэр дотроо олон зуут, аравтад гэх зэргээр шат дараалан засаг захиргаа цэргийн зохион байгуулалтанд орсноор тухайн цаг үеийн нэгэн дэвшилт үйл явдал байлаа. Энэ бол Монголын нийгмийн бодит ахуй, үндэстний өвөрмөц онцлог болон эзэн богд Чингис хааны тэнгэрийн доорхийг эрхшээх их үйлд тэргүүлэх үүрэгтэй байснаас гадна эсгий туургатны ул байгуулагдан бэхжин хойшид улам гүнзгийрэхэд үлэмж үүрэг гүйцэтгэжээ.

Аж аху, эдийн засгийн талаар: Бидний Чингис хаан цэрэг-улс төрийн гарамгай зүтгэлтэн байсан төдийгүй, эдийн засгийг бүхэлд нь зохион байгуулан хөгжүүлж чадсан авъяас чадвартай хүн байснаараа түүхэнд хүндлэгдсэн. Монгол улсын тусгаар тогтнол эцсийн дүнд эийн засгийн хүч чадлын өсөлтөөр баталгаажих учиртайг тэрбээр хэдийн бодолхийлсэн байв. Түүний төрийн гадаад бодлогын утга учир ч энэ л сонирхолд үндэслэж байсан нь тодорхой бүлгээ.

Чингис хаан тухайн нөхцөл байдалд зохион байгуулалт удирдлагын тохиромжтой арга хэлбэрийг хувьд мянгатын системийг үйл ажиллагааныхаа бүхий л хүрээнд чадварлагаар эрэглэсэн гарамгай удирдагч байв. Тэрбээр юуны урьд, нүүдэлчин Монголчуудын гол амжиргаа болсон мал аж ахуйг хөгжүүлэхэд бүхий л анхаарал хүч чармайлтаа чилүүлсэн.

Юуны рьд, “Монголын бат бэх байдлыг бэхжүүлэн хадгалах, улс төр, эдийн засгийн талаа Зүрчидэйн Алтан улсын хараанаас бүрэн гарах явдал чухал байсан билээ. Учир нь, Монга улс жил бүр Алтан улсад мянган лан алтаар алба барьж...”/21/ байсныг зогсоох, хожи нь “Чингис хаан эсгий туургатныг нэгтгэн төр улсаа байгуулж хүчийг олсон үедээ ар түмнийхээ энх амгалан амьдралын төлөө уламжлалт мал аж ахуйг

голлохын зэрэгцээ, хот суурингууд байгуулж, гар урлал, газар тариалан хөгжүүлж, худалдааны их замыг чөлөөтэй байлгаж шударга худалдааг эрхэмлэн төрийн бодлого..."/22/-ыг амжилттай хэрэгжүүлж чадсан билээ..

Мөн үүнээс гадна Монгол орны байгаль, газарзүйн онцлогт зохицсон нүүдлийн мал аж ахуйг улам эрчимжүүлэн хөгжүүлж, урчууд эрхийн төмөр хайлуулах арга ухаанд дэвшилт гаран Монголын цэрэгжсэн нэгдэлийн үйлст эд бодисын нөхцөлийг ханган үйлдвэрлэлийн хүчин гүнзгийрэн хөгжжээ. Харц ард нь хаан эзнээ дагах байр суурь бат болж, нийгмийн ангийн харьцаанд том хувиралт гарав. Энэ бол Монголчуудын балар эртний нийгмийн сүүлчийн овгийн дотоодын боолын эзэмшлийн нийгмийн харилцаанаас феодалын харилцаанд шилжих түүхэн чанартай хувьсал байжээ.

Чингис хаан төрөлх үгээ улсын хэл болгон дүрэмчилж, уйгар үсгийг авиа зүйгээр тэмдэглэн бичих болов. Тататунгаа зарлиг ёсоор Чингис хааны алтан ургынхан болон, ноёд түшмэд тэдний хүүхдүүдэд уйгаржин монгол үсэг, хууль цааз сургасан байна. Энэ бол шинэ тулгар төрд боловсролтой боловсон хүчин бэлтгэгдэн гарах дэвшилт нөхцөлийг бүрдүүлжээ.

Түүхийн бүтээлд тэмдэглэсэнчлэн, Монгол үндэстний сурган хүмүүжлийн түүхийг анх дэвтэрлэн ботилж, хагас зуун хүрэлгүй богино хугацаанд өрний тоон ухаанд нэвтэрсэн Мөнх, Хятад зэрэг дорно дахины соёлд гүнзгий суралцсан Хубилай хаадууд түүхэнд алдаршсан байна. Шинэ тулгар Их Монгол улсын төрөөс, бүр тодруулбал Чингис хаан ард олныхоо мэдлэг-чадварыг туйлаар анхааран, тогтвортой бодлого явуулж эхэлсний үр дүнд түүнийг *Монголын бичиг ном, эрдэм соёлд үлэмж гавъяатан* хэмээн өнөө цагт хүндлэн үзэх болой. Чухам *"тэр үед Чингис хааны өргөөнд "Алтан дэвтэр", "Хөх дэвтэр", "Их засаг", "Их товчоон" зэрэг шастир түүхүүд хөтлөгдөж"*/23/ байсан нь үүнийг батлах бүлгээ.

Гадаад бодлого, дипломат харилцааны талаар: Эл хуралдайн нэгэн чухал хэлэлцсэн зүйл болбоос Монголын эзэнт улс гадаад бодлогоо юуны өмнө өөрийн хил нийлэх улс оронтой тогтмол харилцаа тогтоохыг эрмэлзсэн байна. Ер нь шинэ байгуулсан Монгол улс бол гадаад ертөнцөөс тусгаарлагдмал бин битүү байсан бус харин ч үүний эсрэгээр гадаад улс аймагтай тэр дундаа өөрийн айл зэргэлдээ оршиж байсан улс оронтой харилцаж өөрийгөө хэрхэн үзэж байгаа ба ба түүнтэй ямар хэлбэрийн харилцаа тогтоовол зохихыг мэдэх эрмэлзлэлтэй байжээ. Их Монгол улс байгуулагдсан тэр үед айл зэргэлдээ буюу эртнээс эдийн засаг, соёлын харилцаатай байсан орон газрынхан жирийн ажиглан сонирхох төдийгүй харин молнголын тухай үнэн бодитой мэдээг дам буюу биечлэн олж авах бодлого явуулжээ. Иймээс гадаад монгол улсад элчин илгээж харилцаа тогтоохын хамт улс төр, цэрэг, эдийн засгийн тухай мэдээ хураах, монгол улсыг дайсагнах буюу ямар нэгэн цэргийн холбоонд нөхөр татах, шашин суртахуунаа дэлгэрүүлэх, худалдаа арилжаа хийхийг янз бүрээр өргөжих болсон байна.

XII зууны сүүл, XIII зууны эхэн үеэр Монгол орон нь олон жижиг аймаг, томоохон аймгуудын холбоо, улс ханлигуудын байдлаар саланги тархай оршиж байсан тэдгээр улсуудын дундаас зууны эхэн үеэр Монгол орон нь олон жижиг аймаг, томоохон аймгуудын холбоо, улс ханлигуудын байдлаар саланги тархай оршиж байсан тэдгээр улсуудын дундаас Хамаг Монгол, Найман, Хэрэйд, Мэргид, Татаар зэрэг хүчирхэг ханлигууд нь ихээхэн биеэ даасан бодлого явуулж, Хамаг Монгол, Найман, Хэрэйд, Мэргид, Татаар зэрэг хүчирхэг ханлигууд нь ихээхэн биеэ даасан бодлого явуулж, өвөр зуураа хийгээд хятан гүрэн, түүнчлэн хойд ба өмнөд Хятадад тогтож байсан Алтан улс, Сүн улстай улс төр эдийн засаг, соёлын харилцаанд дипломат харилцаа чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Ийнхүү 1206 оны хуралдайгаар Монголд нэгдсэн тулгар төр улс тогтсоныг зарласан нь *"...урьдын олон жижиг улс ханлигуудын тархай бутархай байдлыг эцэс болгож тэдгээрийн улс төр, эдийн засаг, оюун сэтгэлгэлийн хүчин чадлыг нягтруулан нэгтгэж чадсанаас гадна урьд нь тус тусдаа зөвхөн хори зэргэлдээ улс*

оронтойгоо алдаг оног харилцаж байсан явдлыг төгсгөл болгож”/24/ улам өргөн дипломат харилцааг тогтоох чухал үеийн эхлэл болсон юм.

Тийм учраас Чингис хаан улсаа олон улсын харилцааны тавюцан дээр гаргаж ирмэгцээ гадаад олрчиндоо үнэлгээ дүгнэлт өгч, гадаад бодлогынхоо чиг шугамыг боловсруулан гаргахад ихээхэн шуурхайлжээ. “Тэрбээр Монголын гадаад байдал тийм тааламжтай бус гэж тодорхойлжээ”/25/. Чухамдаа Монгол улсаас дэвшүүлэн тавьсан найрамдал, худалдааны саналыг эс хэрэгсэн дотоодын дажинаас ойн гарсан Татаар, Мэргэд, Найманы салан тусгаарлагчдыг хөрш улс дэмжин өөгшүүлж байсан нь шинэ тулгар улс төрийн хүчний удирдагчдад тэр тусмаа Чингис хааны сэтгэлийг байнга түгшүүлж байсан нь гарцаагүй юм. Их Монголын гадаад бодлогын энэ гол зарчмыг хөрш улсуудын ихэнх нь ойлгохгүй байсан хэдий ч зарим нэгэн ойлгох улсууд байсан байна. Тэр бол Монгол лугаа адил нөхцөлд байсан Түвэд улс болно. Улмаар Түвэдийн Засгийн газар үүнийг ойлгон мэдэрч, 1206 оны сүүлчээр Нялх нэртэй ноён тэргүүлэн 300 гаруй хүнтэй элчийг заран гурван этгээдээсээ хүчирхэг улсуудад шахагдан, гадаад цэрэг улс төрийн хүд байдлаасаа гарахын тулд Их Монгол улсаас өмгөөлөл эрэн Чингис хаанд бараадан байв. Энэ талаар Сагаан Сэцэн өгүүлэхдээ: *“ертөнцийн үйл явдал дутуугийн тул чамайг эс залбай. Би эндээс чам дур шүтсү. Чи тэндээс намайг сахь”*/26/ хэмээн харилцаж байсан нь Чингис хааны гадаад бодлого нь цэрэг дайны хүчээс илүүтэй эв найрамдал, дипломат аргаар шийдвэрлэхийг идэвхтэйгээр эрмэлзэж байсныг харуулж байна.

Мөн элчин төлөөлөгчдөө илгээх, худалдаа арилжааг хийхдээ тагнан турших эчнээ зорилгыг давхар тавьж, тухайн очсон улсын цэрэг, улс төр, эдийн засгийн тухай мэдээг хуримтлуулан авахыг хичээж байсан нь бас л Монгол төр ёсны гадаад бодлогын алтан аргамжааны нэгээхэн хэсэг хэмээн үзэж болохоор байна. Энэ нь мөн цаашдын харилцаа холбоо тэр дундаа цэрэг-улс төрийн бодлогоо амжилттай хэрэгжүүлж, хялбараар эзэлж авахад чухал нөлөөтэй бодлого байсан бүлгээ.

ДӨРӨВ. 1206 онд болсон Их Хуралдайн түүхэн ач холбогдол

Билгийн тоололын гуравдугаар жарны улаан барс жилийн намрын эхэн сард болсон Онон мөрний эхний Их хуралдай нь монголд феодализм төгс бүрэлдэн тогтож улмаар Монгол хэмээх нэр дурьдан буй цаг үеэс хүн төрөлхтөний нийгмийн түүхэн хөгжлийн бодит зүй тогтол, өнөө цагийн дэлхий дахинаар иргэний нийгмийн талаар даяаршин нэгдэх жам ёсыг түүхийн хуудсны нэгэн агшинд манлайлан дэвших нийгэм-улс төр, цэрэг, аж ахуй-соёлын нөхцөл бүрдснийг илэрхийлж байдаг.

Нөгөөтэйгүүр *“1206 онд Их Монгол Улс байгуулагдсан нь Монголын нийгмийн урагшлах хөгжлийн үр дүн мөн бөгөөд тэр үеэс Монголчуудын хоёрдугаар их сэргэн мандалтын үе эхэлсэн”*/27/ гэж судлаачид ончтой тэмдэглэжээ. Мөн түүнчлэн баруун зүгийн Алтайн сүрлэг уулнаас зүүн зүгийн Их Хянганы нуруу хүртэл, өмнө зүгийн түмэн газрын Цагаан хэрмээс умар зүгийн Байгаль далай хүртэлх өргөн уудам нутгийг эзлэн суусан нь монголчууд улс төрийн талаар нэгдэх, монгол угсаатан бүрэлдэн тогтох, хуучин овгийн байгуулалын үлдэцийг бүрэн арилгах, эдийн засаг-үйлдвэрлэхүйн хүчний өсөлт, соёлын хөгжлийг өргөтгөх бололцоог нээж өгсөнөөрөө үнэмлэхүй ач тустай байсан бүлгээ.

1206 онд нүүдэлчин монголчуудын нягдэн нягтарсныг батлан Их Монгол улсыг тунхаглаж, Их төрийн гарамгай жолоодогч Чингис хааны эрднийн сэнтийнээ өлмий лянхуаг шадарлуулснаас гадна тус оронд үйлдвэрлэх хүчин, эдийн засаг, төрийн байгуулал, хууль цааз, соёлын хөгжилд олон чухал ахиц гарчээ.

Эцэст нь тэмдэглэн хэлэхэд, 1206 он бол Монголын түүхэнд хамгийн анхны том чуулган Их Хуралдай чуулсан он болно. Уг хуралдай нь өргөн цар хүрээтэй, нарийн дэг журамтай, онцгой ач холбогдолтой зохион байгуулагдсан төдийгүй эн тэргүүнд 1189 онд болсон Хамаг Монголын нөлөө бүхий ноёдын оролцсон Их хуралдайгаар Хамаг Монгол

Улсын дахин сэргэлтийг зарлан тунхаглаж, хаанаараа алтан ургийн хойчис болох залуу удирдагч Есүхэйн Тэмүжинг сонгосон онцгой үйл явдлын залгамж болсон, өөрөөр хэлбэл, академич Ш.Бирагийн тэмдэглэсэнчлэн *орчин цагийн улс төрийн шинэслэх ухааны гол ухагдахууныг бүрнээ хангасан, хэмжээгүй эрхт хаант засагтай атлаа ардчилалын олон дэвшилт чанарыг өөртөө агуулсан гүн бат, өвөрмөц шинж бүхий Их Монгол Улсыг төв Азийн цээжнээ байгуулан дэлхий дахинд зарлан тунхаглаж, Их Монгол Улсын төрийн хэргийг мэргэн жолоодох эзэн хааныг сонгосоноороо үлэмж эрхэм үйл хэрэг байсан* бүлгээ.

Abstract: 1206 – the significant year of to the Mongolian history in XIII century. Mongolign united ckndition of XII-XIII century ended and was declarated the Great Mongolian Empire in this year. Also the new generation’s beginning of social-political, economic, religious and cultural relitions was built in the XIII century.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Ч.Далай. Монголын түүх.Их Монгол улс /1206-1260 он/. УБ.,1996.тал-94
2. Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ.,1990.тал-28
3. Н.Ишжамц. Монголын нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь.УБ.,1970.тал-41
4. Монгол улсын түүх.Гуравдугаар боть.УБ.,2005.тал-88
5. Н.Ишжамц. Монголын нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь.УБ.,1970.тал-48
6. Монгол Улсын түүх.Гуравдугаар боть.УБ.,2005.тал-85
7. Н.Ням-Осор. Эзэн Чингис хааны Их засаг хууль судлал.УБ.,2003.тал-43
8. БНМАУ-ын түүх.УБ.,1966.тал-124
9. В.Я.Владимирцов. Монголын нийгмийн байгуулал.Нүүдлийн феодализм /орч.У.Гонгоржав/. МҮНС./гар бичмэлийн сан/
10. Н.Ням-Осор. Эзэн Чингис хааны Их засаг хууль судлал.УБ.,2003.тал-43
11. Чэжоу Хун. Монгол, татаарын бүрэн тэмдэглэл. ӨМӨЗО.,2002.тал-35
12. Дэлхий дахины түүх/тэргүүн дэвтэр/.УБ., 2003.т-142
13. Е.Н. Кычанов.Монгол, Тангудын дайн ба Си Ся улс мөхсөн нь. //Монгол, татаар Ази Европт //.УБ.,1984.тал-56
14. Ж.Бор. Монголын дипломат товчоон.УБ.,1998.тал.128
15. И.Дашням. Чингисийн эзэнт гүрний төр, хууль цааз. УБ.,1997.тал-34
16. Монголын соёлын түүх.Тэргүүн дэвтэр.УБ.,1999.тал-319
17. Сайшаал. Чингис хааны товчоон.Тэргүүн дэвтэр.ӨМӨЗО.,1989.тал-354
18. Чигэ. Чингис хаан Монголд аймгуудыг нэгтгэсэн нь. ӨМӨЗО.,1989.тал-182
19. Н.Ням-Осор. Эзэн Чингис хааны Их засаг хууль судлал.УБ.,2003.тал-43
20. Чигэ. Чингис хаан Монголд аймгуудыг нэгтгэсэн нь. ӨМӨЗО.,1989.тал-182
21. Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ.,1990.тал-28
22. Ч.Баянжаргал.Монголын эдийн засгийн түүх.УБ.,2001.тал-40
23. Ш.Шагдар. Монголын боловсролын түүхэн товчоон. УБ.,2000.тал-56
24. Д.Хүүхэнбаатар. Монгол гүрний элчин харилцаа.УБ.,1964.тал-10
25. Ж.Бор. Евроазийн дипломат шастир./хоёрдугаар боть/УБ.,2004.тал-45
26. Мөн тэнд. тал-46
27. Ч.Далай. Монголын түүх.Их Монгол улс /1206-1260 он/. УБ.,1996.та.-94